БАТЛАВ.
ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Д.МӨНХБААТАР

# “ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН ҮЙЛДВЭРИЙН БАЙРНЫ ИЖ БҮРЭН ДЭЭВЭР ЗАСВАРЫН АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 06 сарын 12-ны өдөр Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1 | Ажил гүйцэтгэх үндэслэл | 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил |
| 2 | Барилга байгууламжийн байршил | СХД, 18 дугаар хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж, “ГСШТ” ТӨҮГ, өөрийн байр |
| 3 | Зориулалт | - Дээвэр засвар |
| 4 | Ажил гүйцэтгэх үе шат | <u>2 үе шаттай</u>.<br>1. Дээврийн засварын хэмжилтийн ажлын зураг боловсруулж, төсөвт магадлал хийлгэх.<br>2. Дээвэр засварын ажил гүйцэтгэж, хүлээлгэж өгөх. |
| 5 | Төслийн иж бүрдэл | Ажлын зураг<br>Төсөв<br>Магадлалын ерөнхий дүгнэлт<br>Бусад холбогдох материал |
| 6 | Онцгой нөхцөл | PVC Мембран материал байх |
| 7 | Ажил гүйцэтгэхэд ашиглах материал | <u>Хууль тогтоомжууд:</u><br>- Барилгын тухай Монгол улсын хууль<br><u>Норм, дүрэм:</u><br>- Дээврийн ажил БНбД 31-07-05<br>- Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05<br>- Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНбД 21.02.02/, /БНбД 21.01.02/<br><u>Стандартууд:</u><br>- Дээвэр болон ус тусгаарлалтын PVC мембран. Техникийн ерөнхий шаардлага MNS 6303-2011<br>- Ус үл нэвтрүүлэх хуйлмал материал ТУ 5774-002-13157915-98<br>- Гөлмөн төмөр MNS 3154-1984<br>- Уур ус тусгаарлагч материал UCS1503C |
| 8 | Ерөнхий шаардлага | <u>Аюулгүй байдал хангах ажил:</u><br>- Ажил эхлэхээс өмнө ажил гүйцэтгэж буй албан хаагчдад ХАБЭА-н зааварчилгааг тогтмол өгөх.<br><u>Дээвэр хуулж, буулгаж тээвэрлэх ажил:</u><br>- Дээвэр дээрх холбооны болон цахилгааны утас цэгцэлж ажил хийхэд саадгүй болгоно.<br>- Ажил гүйцэтгэхээс өмнө болон дараа гарах дээврийн хог, хаягдлыг зориулалтын шат ашиглан буулгаж дор бүр нь тээвэрлэнэ.<br><u>Бохирын болон агааржуулах хоолойн засварын ажил:</u> |

| | | |
|---|---|---|
| | | - Агааржуулалтын хоолой тоосгон өрлөг, шаврын ажлыг шинээр хийнэ<br>- Агааржуулалтын бетон тавцанг шинээр солино.<br>- Эвдэрч гэмтсэн, шаардлага хангахгүй байгаа бохирын яндан хоолойг шинээр солих, зориулалтын агааржуулалтын малгайвч төмөр хийнэ.<br>- Үерийн ус зайлуулах хоолойн хог, лаг, шавар цэвэрлэж хамгаалалтын төмөр тор хийх бөгөөд шаардлагатай бол ус зайлуулах хоолойг шинээр солих буюу засварлана.<br>Дээврийн хуйлмал материалын ажил:<br>- Үйлдвэрийн байрны иж бүрэн дээврийг pvc мембранаар хийх, хадаас буюу шүрүүпны алхмын хэмжээ 30 см тутамд нэг байна.<br>- Дээвэрт PVC мембран (АНУ-тай дүйцэх) дэвсэх парпедыг бүрэн бүрхэнэ, хуйлмал материалын зөрлөг 10см-ээс багагүй байх<br>- Дээвэрт геотекстиль дэвсэх<br>- Стандартын дагуу мембран амьсгалжуулагч хийх<br>- 4 давхрын хөмсөг нь дээр PVC мембран (АНУ-тай дүйцэх) дэвсэх<br>- Шингэн мембранаар өргөтгөлийн дээврийн ажил хийх<br>Парапетны засвар, шинэчлэлийн ажил:<br>- Парапетны төмөр шинээр солих<br>- Парапет хана нурсан, эвдэрсэн бол шаардлагатай нөхөн сэргээх өрлөг, шавар хийж засварлана.<br>- Парапетны дээд хэсэгт тэгшилгээ шавар хийх<br>- Байгалийн давагдашгүй хүчин зүйл болох /хуй салхи, аадар бороо/ хийсэхгүй, ус орохгүй байхаар тооцоолж парапед төмрийг хоёр талаас нь хадаж бэхэлгээ хийж өгнө.<br>Дээврийн борооны ус зайлуулах шугамын ажил:<br>- Борооны ус зайлуулах шугам хоолойг цэвэрлэж, хог хаягдлаас хамгаалах шүүр, таг тавьж өгнө. Шаардлагатай бол шинээр хийнэ.<br>Цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан ажлын төлөвлөгөө, график гарган байгууллагын ажилчид болон дээврийн ажил хийж гүйцэтгэж байгаа ажилтнуудад хохирол учруулалгүй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаан ажиллана. |
| 11 | Эдийн засгийн тооцоо, төсөв | - Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох. |

ХЯНАСАН:

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.НАСАНБУЯН

БОЛОВСРУУЛСАН:

ТЗҮХ-ИЙН ДАРГА С.ГОНЧИГСҮРЭН